



УЛААНБААТАР
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2021 оны 09 сарын 07 өдөр

Дугаар 6/456

Улаанбаатар хот

Б.Одонтуяаг ажлаас чөлөөлж,
тэтгэмж олгох тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8, 38 дугаар зүйлийн 38.1.1, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, Компанийн Хөдөлмөрийн дотоод журмын 4 дүгээр зүйлийн 4.23, Компанийн Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан 2019-2020 онд мөрдөх Хамтын гэрээний 5 дугаар зүйлийн 5.14 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан Баянзүрх хэрэглэгчдэд үйлчлэх төвийн Авлага барагдуулах хэсгийн монтер /авлага барагдуулагч/ Буянгийн Одонтуяа /303461/-г 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс үүрэгт ажлаас нь чөлөөлж, хөдөлмөрийн гэрээг цуцалсугай.

2. Б.Одонтуяаг эрчим хүчний салбарт 17 жил ажилласны тэтгэмжийг эрчим хүчний салбарт ажилласан жил тутамд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ /672000/-г 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тооцож 22,848,000 /хорин хоёр сая найман зуун дөчин найман мянга/ төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг олгохыг Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /О.Ариунболд/-д зөвшөөрсүгэй.

3. Б.Одонтуяагийн ажлыг хүлээлцүүлж, ээлжийн амралтын олговрыг 2.33 хоногоор тооцож олгох, холбогдох тооцоог хийж дуусгахыг Баянзүрх хэрэглэгчдэд үйлчлэх төвийн дарга /К.Эрдэнэбаяр/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга /Б.Баттүшиг/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Р.ДАГДАН